

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул Дүүргийн Тохижилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/044/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

НТАГ-ын Дэд дарга Ч.Болд

Утас:70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр

Утас:70007734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Алтанцэцэг

Утас:325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

“Эс Жи Эм Ди-Аудит” ХХК

Захирал: Д.Эхбаяр

Утас: 70006948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/317
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ
ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
В.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул Дүүргийн Тохижилт Үйлчилгээний Төв ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Хан-Уул дүүргийн Засаг даргын Захирамжаар дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд цэцгийн үрсэлгээ, цэцгийн мандал байгуулах ажлын зардалд 157.8 сая төгрөг, иргэдийн бүлгийг түр ажлын байраар хангахад зориулж 83.5 сая төгрөгийг олгож, цалингийн зардлаар тайлагнасан байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн хур хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлэх ажлыг хавар болон намрын улиралд 2 удаа зохион байгуулж, ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлж, Дүүргийн Засаг даргын захирамжаар 593.2 сая төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус төвд Хан-Уул дүүргийн Засаг Даргын тамгын газраас 1,139.9 сая төгрөгийн хог тээврийн машин, замын тоос сорогч мехнизм зэргийг үнэ төлбөргүй өгсөн байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 91.6 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

1425010174

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	465,441,675.53	1,626,909,917.44
1.1.2	Дансны авлага	10,350,787.31	10,350,488.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.0	129,972,867.08
1.1.6	Бараа материал	689,623,917.42	619,054,586.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.0	19,000,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,165,416,380.26	2,405,287,859.75
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,887,113,808.64	3,635,791,585.94
1.2.2	Биет бус хөрөнгө	145,777.88	129,777.92
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,887,259,586.52	3,635,921,363.86
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,052,675,966.78	6,041,209,222.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	20,094,316.00	4,084,316.00
2.1.1.3	Татварын өр	13,303,496.02	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	33,397,812.02	4,084,316.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		1,139,967,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	1,139,967,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	33,397,812.02	1,144,051,316.00
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1.	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.5.	Нэмж төлөгдсөн капитал	1,000,000.00	1,000,000.00
2.3.8.	Эздийн өмчийн бусад хэсэг	1,628,853,000.00	1,628,853,000.00
2.3.9.	Хуримтлагдсан ашиг	2,389,425,154.76	3,267,304,906.61
2.3.11.	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,019,278,154.76	4,897,157,906.61
2.4	ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	4,052,675,966.78	6,041,209,222.61

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,289,360,518.00	9,291,864,139.36
2	Борлуулалтын өртөг	41,500,000.00	-
3	Нийт ашиг (алдагдал)	6,247,860,518.00	9,291,864,139.36
5	Хүүний орлого	3,123,159.53	5,647,771.94
8	Бусад орлого	15,465,600.00	248,887,240.68
10	Ерөнхий ба удирдлагын зардал	6,404,462,277.58	8,586,386,397.94
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(138,013,000.05)	960,012,754.04
19	Орлогын татварын зардал	1,546,559.99	95,436,498.21
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(139,559,560.04)	864,576,255.83
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(139,559,560.04)	864,576,255.83
23	Бусад дэлгэрэнгүй орлого		1,139,967,000.00
23.3	Бусад олз, гарз		1,139,967,000.00
24	Орлогын нийт дүн	(139,559,560.04)	2,004,543,255.83
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00		2,528,984,714.80	2,529,984,714.80
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	2,528,984,714.80	2,529,984,714.80
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(139,559,560.04)	(139,559,560.04)
5	Өмчид гарсан өөрчлөлт		1,628,853,000.00		1,628,853,000.00
9	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	1,628,853,000.00	2,389,425,154.76	4,019,278,154.76
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			13,303,496.02	13,303,496.02
11	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	1,628,853,000.00	2,402,728,650.78	4,032,581,650.78
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			864,576,255.83	864,576,255.83
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	-	3,267,304,909.61	4,897,157,906.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	6,292,483,677.53	9,297,511,911.30
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	1,955,227,997.53	1,436,781,436.30
	Татаас санхүүжилтийн орлого	4,337,255,680.00	7,860,730,475.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	6,495,507,990.02	8,050,168,269.39
	Ажиллагчдад төлсөн	2,197,090,750.64	3,278,829,236.15
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	699,372,047.34	953,334,696.02
	Бараа материал худалдан авахад төлсөн	36,886,400.00	41,980,300.00
	Ашиглалтын зардалд төлсөн	114,523,701.74	183,596,774.50
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	119,793,000.00	119,793,000.00
	Татварын байгууллагад төлсөн	317,061,278.98	317,061,278.98
	Даатгалын төлбөрт төлсөн	12,225,817.00	12,225,817.00
	Бусад мөнгөн зарлага	2,998,554,994.32	2,998,554,994.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(203,024,312.49)	(203,024,312.49)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	127,515,618.00	87,875,400.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	127,515,618.00	85,875,400.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(127,515,618.00)	(85,875,400.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(330,539,930.49)	1,161,468,241.91
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	795,981,606.02	465,441,675.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	465,441,675.53	1,626,909,917.44

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны биелэлт	2024 оны зорилт	2024 оны биелэлт	Зөрүү	Хувь	
1	Орлого	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	4,337,255.7	6,289,020.74	7,860,730.48	(1,571,709.74)	124.9
		Борлуулалтын орлого	1,955,228.0	2,835,080.60	1,436,781.44	1,398,299.16	78.3
		Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,465.6	-	248,887.24	(248,887.24)	-
		Нийт орлого	6,307,949.3	9,124,101.33	9,546,399.16	(422,297.89)	104.6
2	Зардал	ББӨртөг	-	-	-	-	-
		Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,731,278.30	3,550,661.78	4,041,779.75	(491,117.97)	113.8
		Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	393,223.61	511,190.70	521,217.70	(10,027.00)	101.9
		Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,523.70	148,880.81	182,096.77	(33,215.96)	122.3
		Бичиг хэргийн зардал	3,499.07	4,548.79	6,980.49	(2,431.70)	153.4
		Тээвэр, шатахууны зардал	457,271.04	594,452.35	464,814.55	129,637.80	78.2
		Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,433.98	18,764.18	15,726.59	3,037.59	83.8
		Ном, хэвлэлийн зардал	-	-	10,835.00	(10,835.00)	-
		Хог хаядал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	808,587.99	1,051,164.38	916,371.30	134,793.08	87.2
		Бага үнэтэй, түргэн эдэгдэх, ахуйн эд зүйлс	16,968.86	22,059.52	22,404.12	(344.60)	101.5
		Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	131,037.91	170,349.28	184,532.37	(14,183.09)	108.3
		Нормын хувцас, зөөлөн эдлэл	108,531.84	141,091.40	154,180.80	(13,089.40)	109.3
		Багаж, техник, хэрэгсэл	1,606.30	2,088.19	17,464.91	(15,376.72)	836.4
		Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	42,679.72	55,483.64	107,381.92	(51,898.28)	193.5
		Тохижилт /урсгал засвар/	899,316.28	1,169,111.17	563,847.73	(605,263.44)	48.2
		Томилолт, зочны зардал	7,257.00	10,159.79	11,535.40	(1,375.61)	113.5
		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,595.11	195,773.64	370,000.63	(174,226.99)	189.0
		Даатгалын үйлчилгээ	11,754.08	15,280.31	22,163.52	(6,883.21)	145.0
		Тээврийн хэрэгслийн татвар, оношлогоо	495.00	643.50	1,022.57	(379.07)	158.9
		Газрын төлбөр	1,039.66	1,351.56	4,197.89	(2,846.33)	310.6
		Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000.00	9,100.00	7,000.00	2,100.00	76.9
		Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,032.66	1,342.45	777.98	564.47	57.9
		Хүүний төлбөрт төлсөн -ТӨҮГ	-	-	-	-	-
		Татварын байгууллагад төлсөн	6,544.39	8,507.71	3,163.85	5,343.86	37.2
		Бусад мөнгөн зарлага	19,674.16	25,576.41	11,464.05	14,112.36	44.8
		Бараа үйлчилгээний бусад зардал	193,072.42	250,994.15	370,558.64	(119,564.49)	147.7
		Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	-	-
		Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	312,739.20	406,560.96	551,067.86	(114,506.90)	135.5
		Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-	-	-

	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,800.00	15,340.00	42,800.00	(27,460.00)	279.0
	Нийт зардал	6,445,962.28	8,380,476.66	8,586,386.40	(205,909.74)	102.5
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(138,013.00)	743,624.67	960,012.76	(216,388.09)	129.1
4	Татварын зардал	-	74,362.47	95,436.50	(21,074.03)	128.4
5	Татварын дараах ашиг (алдагдал)	(138,013.00)	669,262.20	864,576.26	(1,204,184.36)	279.8
6	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	0.98	1.09	1.11		
7	Авлага	10,350.79	10,350.8	140,323.4	(129,972.9)	1,355.7
8	Өглөг	20,094.32	33,397.8	1,144,051.31	(1,110,653.51)	3,425.5
9	Хөрөнгө оруулалт	127,515.62	200,000.00	85,875.40	114,124.60	42.9

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,158,967.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Дулаан гражын түрээсийн төлбөрийг гэрээ байгуулан 3 сараар тооцож урьдчилан төлсөн бөгөөд урьдчилж төлсөн зардлыг дутуу тайлагнасан;
- Тайлант хугацаанд Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгийн газраас үнэ төлбөргүй өгсөн 1,139,967.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнаагүй;

Аудитаар нийт 735,496.5 мянган төгрөгийн 9 зөрчил¹ илэрснээс, 50,190.5 мянган төгрөгийн зөрчилд 2 хариуцлага тооцох албан шаардлага, 420,015.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 265,190.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

1. Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг (13,945.1 мянган төгрөг) тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх 184/22310594 дугаартай албан шаардлагыг заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд 10,350.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

2. Бэлэн мөнгөний кассаас анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4,015.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

3. Тайланд онд элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгийн (386,444.6 мянган төгрөг) үнийг шинэчлэн тогтоолгох хүсэлтийн эрх бүхий байгууллагад

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүргүүлж шийдвэрлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" , Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 271 дүгээр тогтоолын 7.1-д " Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хгуацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийн үнийг эрх бүхий байгууллагад хандан, шинэчлэн тогтоох, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээд тарьц суулгац худалдан авах 416,100.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн үнэлгээний хороо тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг тендер нээсэн өдөр эхлүүлээгүй байна. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах тухай мэдэгдлийг Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгийн газраас хүргүүлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш нэг цагийн дотор тендерийг нээнэ", 23.2-т "Тендерийг нээж, дараах мэдээллийг цахим системээр зарлана:", 23.2.1-т "оролцогчийн нэр;", 23.2.2-т "тендерийн үнэ;", 23.2.3-т "санал болгосон үнийн хөнгөлөлт;", 23.2.4-т "хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ;", 23.2.5-т "тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад тендерийн баталгаа ирүүлсэн эсэх.", 51 дүгээр зүйлийн 51.2-т "Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Нийслэлийн засаг даргын А19 захирамжийн хүрээнд олгосон хөрөнгө болох (120,080.0 мянган төгрөг) ногооны үр худалдан авахдаа тендер шалгаруулалтгүй худалдан авсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 187/22310594 дугаартай албан шаардлагыг заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд 39,840.0 мянган төгрөгөөр цэцгийн үрийг сонгон шалгаруулалтгүй шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." заалтууд, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагатай бараа материалыг сонгон шалгаруулалтгүй худалдан авсан зөрчлийг зогсоож, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

2. Зөвлөмж

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тус төв нь бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсан ажилчдын илүү цагийн хөлсийг хуулийн дагуу олгоогүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.1-д "Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын илүү цагийн хөлсийг хууль журмын дагуу тооцон олгож байх;

2. Ээлжийн амралтын олголттой холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Ажлаас чөлөөлсөн ажилтнуудад эцсийн тооцоо хийж 412.6 мянган төгрөгийн амралтын мөнгийг олгоогүй байна. Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Ээлжийн амралт олгох журам, ээлжийн амралтын цалин тооцох журамын 2.8-д "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: 1/ ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; 2/ ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалж байгаа ажилчдын ээлжийн амралтын тооцоог хийж ажиллах;

3. Тайлант онд өөрийн хэрэгцээт 23,358.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтын цахим дэлгүүрээс хийгээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгцээт бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгсөн.

4. Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлогын 41,419.1 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 200,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дулаан гражын түрээсийн төлбөрийг гэрээ байгуулан 3 сараар тооцож урьдчилан төлсөн бөгөөд урьдчилж төлсөн зардлыг дутуу тайлагнасан.	1	19.0	1	19.0	-	-	1	19.0	-	-	-	-
Тайлант хугацаанд Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгийн газраас үнэ төлбөргүй өгсөн 1,139,967.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнаагүй.	1	1,140.0			1	1,140.0	1	1,140.0				
Дүн	2	1,159.0	1	19.0	1	1,140.0	2	1,159.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Кассаас зарцуулсан 4,015,5 мянган төгрөгийн зарлагын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	4.0					1	4.0		
Тайлант оны эхэнд байсан 10,350,5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	10.3			1	10.3				
Тайланд онд элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн 386,444.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоолгох хүсэлтийн эрх бүхий байгууллагад хүргүүлээгүй байна.	1	0.0					1	0.0		
Тус төв нь ажилчдаа ажлын 6 өдөр ажиллуулдаг бөгөөд бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсанд цалин тооцохдоо хуулийн дагуу илүү цагийн нэмэгдэл тооцохгүй ажлын өдөртэй адил тооцож олгосон байна.	1	0.0							1	0.0
Ажлаас чөлөөлсөн ажилтнуудад эцсийн тооцоо хийж амралтын тооцоог бодоогүй байна.	1	0.4							1	0.4
Дүн	5	14.8			1	10.3	2	4.0	2	0.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Тайлант онд өөрийн хэрэгцээт бараа материалын худалдан авалтын цахим дэлгүүрээс хийгээгүй байна.	1	23.4							1	23.4

Тайлант онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээд тарьц суулгац худалдан авах 416,100.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн үнэлгээний хороо тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг тендер нээсэн өдөр эхлүүлээгүй байна. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах тухай мэдэгдлийг Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгийн Газраас хүргүүлсэн.	1	416.1					1	416.1		
Тайлант хугацаанд 39,840,000 төгрөгөөр цэцгийн үрийг сонгон шалгаруулалтгүй шууд худалдан авсан байна.	1	39.8			1	39.8				
Дүн	3	479.3			1	39.8	1	416.1	1	23.4
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил										
Шилэн дансанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлогын 41,419.1 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 200,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	241.4							1	241.4
Дүн	1	241.4							1	241.4
Нийт дүн	4	720.7			1	39.8	1	416.0	2	264.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Нийслэлийн Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			